



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хст,
Чингэлтэй дүүрэг, Жуулчины гудамж 5,
Утас: 26-65-92, Факс: (976-11) 32-65-92,
E-mail: meteoagency@reginnet.mn

2015-12-10 № 1/654


танай _____-ны № _____-т

**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БОЛДБААТАР ТАНАА**

"Монгол орны 2016 оны I-III сарын цаг
агаарын урьдчилсан төлөв"-ийг сараар нарийвчлан
гаргаж, хүргүүлж байна.

Хүндэтгэсэн

ДАРГА



Д.ЦОГТ-ОЧИР

0184



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
УС ЦАГ УУР ОРЧНЫ СУДАЛГАА
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН



МОНГОЛ ОРНЫ 2016 ОНЫ I-III САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ



Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

2016 ОНЫ III САРЫН
ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

2015 оны 12 дугаар сар

Монгол орны I-III сарын уур амьсгалын тойм

Нэгдүгээр сард. Агаарын температурын сарын дундаж нь Увс, Сэлэнгийн ихэнх нутаг, Завханы хойд, Ховд, Баянхонгорын зүүн хойд, Хөвсгөлийн баруун хэсгээр 24-32 градус, Баян-Өлгийн хойд, Говь-Алтай, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутаг, Баянхонгорын өмнөд, Архангайн өмнөд, Булганы зүүн хэсгээр 11-17 градус, бусад нутгаар 18-23 градус хүйтэн байдаг(1 дүгээр зураг).

Увс, Булганы хойд, Хөвсгөлийн баруун, Ховд, Архангайн өмнөд, Өмнөговийн баруун хойд, Хэнтийн зүүн, Дорнодын зүүн өмнөд хэсэг, Завхан, Сэлэнгийн ихэнх нутгаар 2-3 мм, бусад нутгаар 1-1,5 мм цас ордог (3 дугаар зураг).

Хоёрдугаар сард. Агаарын температурын сарын дундаж нь Увсын ихэнх нутаг, Завханы хойд, Баянхонгорын баруун хойд, Хөвсгөлийн баруун, Сэлэнгийн зүүн хэсгээр 20-28 градус, Баян-Өлгийн хойд, Говь-Алтай, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Дорноговийн ихэнх нутаг, Ховд, Баянхонгор, Архангайн өмнөд, Төв аймгийн баруун өмнөд хэсгээр 6-14 градус, бусад нутгаар 15-20 градус хүйтэн байдаг (5 дугаар зураг).

Увс, Завханы хойд, Хөвсгөлийн баруун өмнөд, Булганы зүүн хойд, Ховд, Архангайн өмнөд, Хэнтийн зүүн, Сүхбаатар, Дорнодын зүүн өмнөд хэсгээр 2-3 мм, бусад нутгаар 0-1,5 мм цас ордог (7 дугаар зураг).

Гуравдугаар сард. Агаарын температурын сарын дундаж нь Увс, Завхан, Баянхонгорын хойд, Хөвсгөл, Архангайн баруун хэсгээр 11-17 градус, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсэг, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар 2-5 градус, бусад нутгаар 5-10 градус хүйтэн байдаг(9 дүгээр зураг).

Увсын зүүн, Завханы баруун хойд, Булган, Хэнтийн зүүн хойд, Архангай, Сүхбаатар, Дорнодын зүүн өмнөд хэсгээр 3-8 мм, бусад нутгаар 3 мм хүртэл цас ордог(11 дүгээр зураг).

Гэхдээ жил бүрийн өвөл харилцан адилгүй байдаг. Тухайлбал: Сарын дундаж температур манай орны ихэнх

нутгаар 1990, 1993, 1998, 1999, 2002 оны I-III сард 3-7 градусаар дулаан болж, хоногийн үнэмлэхүй их температур говь талын нутгаар 15-20 градус хүрч дулаарч байсан бол 1945, 1957, 1977, 1981, 1984, 2001 оны I сард 3-6 градусаар хүйтэн болж, 1944-1945, 1956-1957, 1976-1977, 2005 оны өвөл Увс, Завхан, Баянхонгор, Хөвсгөлийн хойд хэсгээр шөнөдөө 45-55 градус хүрч хүйтэрч байв.

1975, 1987, 1988, 1993, 2001, 2002, 2009-10 онд зарим нутгаар олон жилийн дунджаас 3-5 дахин их цас орсон бөгөөд 1990, 1993 оны хаврын эхээр Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Өмнөговийн нутгаар 5-7 хоногт 20-56 мм нойтон цас орсон нь сүүлийн 30 гаруй жилд тохиолдоогүй онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч олон мянган мал хорогдсон байна.

Олон жилийн дундаж байдлаар I сард цасны дундаж зузаан говийн нутгаар 1-4, баруун ба төвийн нутгийн хойд хэсгээр 10-15, бусад нутгаар 4-9 см хүрдэг. Цас их орсон жил уулархаг нутгаар 24-30, бусад нутгаар 18-20 см хүрдэг бөгөөд 1987, 2001-2003, 2005, 2007, 2010 оны I сард цасны дундаж зузаан уулархаг нутгаар 40-45, хунгарласан газраа 60-80 см хүрч мал өвөлжилтийн байдал онцгой хүндэрч байв.

2016 оны I-III сарын цаг агаарын урьдчилсан төлөв

Нэгдүгээр сард. Агаарын температурын сарын дундаж нь Баян-Өлгий, Ховдын нутаг, Говь-Алтайн баруун хэсгээр уур амьсгалын дунджаас 0.5-1,0 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байна(2 дугаар зураг).

Баян-Өлгий, Увс, Сүхбаатарын ихэнх нутаг, Завханы баруун өмнөд, Ховд, Дорноговийн хойд, Хэнтийн зүүн өмнөд, Дорнодын өмнөд, Дорноговийн баруун өмнөд хэсгээр уур амьсгалын дунджаас ахиу, Говь-Алтай, Баянхонгорын өмнөд, Өмнөговийн баруун хэсгээр дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй (4 дүгээр зураг).

Хоёрдугаар сард. Агаарын температурын сарын дундаж нь Баян-Өлгий, Увс, Ховдын ихэнх нутаг, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговийн өмнөд, Завханы хойд, Хөвсгөлийн баруун хэсгээр уур амьсгалын дунджаас 0,5 градусаар дулаан, Сүхбаатар, Дорнодын зүүн өмнөд хэсгээр уур амьсгалын дунджаас 0,5 градусаар хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байна(6 дугаар зураг).

Баян-Өлгий, Архангай, Булган, Сүхбаатар, Дорнодын ихэнх нутаг, Завхан, Хөвсгөл, Дорноговийн зүүн, Ховд, Баянхонгорын хойд хэсгээр уур амьсгалын дунджаас ахиу,

зөвхөн Ховдын өмнөд хэсгээр дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй (8 дугаар зураг).

Гуравдугаар сард. Агаарын температурын сарын дундаж нь Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дорнодын ихэнх нутаг, Өвөрхангайн хойд, Архангай, Сүхбаатарын зүүн хэсгээр уур амьсгалын дунджийн орчим, бусад нутгаар дунджаас 0.5-1,0 градусаар дулаан байх төлөвтэй (10 дугаар зураг).

Баян-Өлгий, Ховд, Увс, Хөвсгөл, Хэнтийн ихэнх нутаг, Говь-Алтайн баруун, Завхан, Архангай, Булган, Сүхбаатарын хойд, Төв, Сэлэнгийн зүүн, Өмнөговийн зүүн өмнөд, Дорноговийн өмнөд хэсгээр уур амьсгалын дунджаас ахиу, Говь-Алтайн зүүн, Баянхонгорын өмнөд, Өмнөговийн баруун хэсгээр дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй (12 дугаар зураг).

2016 оны I-III сарын цаг агаар хөдөө аж ахуйд хэрхэн нөлөөлөх талаар

1-3 дугаар сарын цаг агаарын төлөвийн мэдээгээр агаарын температур 1 ба 2 дугаар сард нутгийн ихэнх хэсэгт олон жилийн дунджийн орчим, 3 дугаар сард дунджаас дулаан, хур тунадас 1-3 дугаар сард ихэнх нутгаар дунджийн орчим ба түүнээс ахиу орохоор байна.


Одоогийн байдлаар нутгийн 90 орчим нь цасан бүрхүүлтэй, Увс, Завхан, Баянхонгор, Булган, Хэнтий, Дундговь, Төв, Сүхбаатарын ихэнх, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Хөвсгөл, Архангай, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Нийслэл, Говьсүмбэр, Дорноговь, Дорнодын зарим сумдын нутагт 5-9 см зузаан буюу нягт нь 0,01-0,29 гр/см³, Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Булган, Сэлэнгэ, Төв, Дундговь, Дорноговь, Хэнтий, Сүхбаатарын зарим сумдад 10-19 см зузаан, нягт нь 0,07-0,20 гр/см³, Завханы Яруу, Баянтэс, Баянхайрхан, Тэс суманд 20-22 см зузаан, нягт нь 0,13-0,20 гр/см³ байна. Мөн 12 дугаар сарын урьдчилсан мэдээгээр нутгийн хойд хагаст дунджаас хүйтэн, хур тунадас ихэнх нутгаар дунджаас ахиу ба орчим байх мэдээтэй байна.

Өнгөрсөн зуны зуншлага, бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн даац, энэ жилийн цасны зузаан, нягт, 12 дугаар сарын хур тунадас, агаарын температурын урьдчилсан мэдээ зэргийг нэгтгэн гаргасан Монгол орны 2015-2016 оны өвөлжилтийн төлөө, эрсдэлийн тойм мэдээгээр нийт нутгийн


40 гаруй хувь нь эрсдэл ихтэй гарсан.

Энэ жилийн хувьд зарим нутагт цас бага багаар хялмаалан орж, салхи шуурга тогтуун байж, дулаан байснаас өөс ургамал бамбарлах, цасны өнгөн хэсэг хатуурах, нягтрах зэргээр мал бэлчээрлэлт таагүй байх нөхцлийг бий болгоод байна.


Ирэх оны эхний 3 сарын цаг агаарын төлөөр цас олон жилийн дунджийн орчим ба ахиу орох, агаарын температур төдийлөн дулаан байхааргүй байгаа нь цаашид малын харилцаа маллагаа хүндрэх, өөс ногоо цасанд дарагдах, тэжээл дутагдах, хашаа сараач шаардагдах, мал хайрагдаж турах ялангуяа одоогийн байдлаар эрсдэл ихтэй байгаа нутгаар өвөлжилт, хаваржилтыг улам хүндрүүлэх төлөөтэй байгааг анхаарна уу.




1 дүгээр зураг. 1 дүгээр сарын агаарын температурын олон жилийн дундаж (C)




3 дугаар зураг. 1 дүгээр сард орох хур тунадасны олон жилийн дундаж (мм)




2 дугаар зураг. 1 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв




4 дүгээр зураг. 1 дүгээр сард орох хур тунадасны урьдчилсан төлөв




5 дугаар зураг. 2 дугаар сарын агаарын температурын олон жилийн дундаж (°C)




7 дугаар зураг. 2 дугаар сард орох хур тунадасны олон жилийн дундаж (мм)




6 дугаар зураг. 2 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв




8 дугаар зураг. 2 дугаар сард орох хур тунадасны урьдчилсан төлөв




9 дүгээр зураг. 3 дугаар сарын агаарын температурын олон жилийн дундаж (C)



11 дүгээр зураг. 3 дугаар сард орох хур тунадасны олон жилийн дундаж (мм)




10 дугаар зураг. 3 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв



12 дугаар зураг. 3 сард орох хур тунадасны урьдчилсан төлөв

2015-2016 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН ТӨЛӨВ, ЭРСДЭЛИЙН ЗУРАГ



Таних тэмдэг:

- Аймгийн төв
- Сумын төв
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Нуур

Эрсдэлийн зэрэг:

- Хамгийн бага эрсдэлтэй
- ▨ Бага эрсдэлтэй
- ▩ Дунд эрсдэлтэй
- ▧ Их эрсдэлтэй
- Нэн их эрсдэлтэй

0 125 250 500 750 1,000 километр

Боловсруулсан: Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
 Огноо: 2015 оны 11 дүгээр сарын 24
 Вэб хаяг: www.lbag-agaar.mn, www.lcc.mn
 О-шуудан: mtb@maglonef.mn
 Утас: 321523, 70110638 Факс: 329468